

ШИНЭСТ ХК-НИЙ 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 3-р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Бид 2019 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн Мэйжор Дриллинг Монгол ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгыг бүрэн түрээслэж эхлээд жил болж байна. СХД, 32-р хороо, Хуучин Авто худалдааны төвийн ойролцоо байрлах 864м² талбай бүхий сэндвичэн барилгыг түрээслэж зарим тоног төхөөрөмжөө ажилуулж эхлээд байна. Мөн ХУД, 3-р хороонд байрлах Мишээл Мега Молл ХХК-н талбайд байрлах контейнерыг түрээсэлж бэлэн бүтээгдэхүүнүүдээ тэндээсээ борлуулалт хийж байна. Зарим модон бэлдэц тоног төхөөрөмжөө БЗД-ийн Амгалан гаалийн хяналтын бүсийн хажууд сэндивч түрээслэн хадаглаж байгаа.

Одоогоор бид дахин үйлдвэр барих эсэх, цаашид өөр том обект газар түрээслэх зэрэг асуудлыг судлаж байна. Дэлхийн нийтэд гараад байгаа цар тахал COVID –с үүдэн зах зээл эргэлт муу удааширлалтай байгаа тул бид судалгааны түвшинд ажилаа хийж байна. Түрээслэгч газраас оффисийн барилгын дотор засалыг хийх шаардлага хүргүүлсэн бөгөөд бид эхний ээлжийн дотор засвар үйлчилгээг хийж гүйцэтгээд байсан ба цар тахалтай холбоотойгоор зарим дотор засвар дуусаагүй байна.

Цаашид түрээслэгч байгууллагаас ирсэн саналт хүсэлт засвар үйлчилгээг хийхээр ажиллаж байна. Цар тахалтай холбоотойгоор үйлдвэрлэл зогссонг байдалтай байгаа бөгөөд төлөвлөсөн ажил төлөвлөгөөг ч бас удааширлалтай байгаа

Үйл ажиллагаа:

1. Хaan банкнаас зээлсэн богино хугацаат зээл авж үйлдвэрийн хашаа болон дотор зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгээд байна.
2. ХХБ-наас авсан 500,000,000 төгрөгийн бизнесийн зээлийн эргэн төлөлтөө төлөөд явж байна.

3. Мишээл Мега Молл ХХК-д павильон түрээсэлж, наамал дүнзэн хаусын материалыар бүрэн тохижуулан үйл ажиллагаагаа одоогийн байдалаар тэндээс үйл ажиллагаа борлуулалтаа явуулан ажиллаж байна.
4. Эрсдлээс урьдчилан сэргийлж Тэнгэр Даатгал ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгуудаа дараах эрсдлээс хамгаалж даатгалын гэрээгээ сунгаж даатгууллаа.
 - Гал түймэр, дэлбэрэлт
 - Байгалийн гамшигийн бүх эрсдлүүд
 - Ус чийгний нөлөөллийн эрсдэл
 - Цахилгаан эрчим хүчний эрсдэл
 - Цонхны шилний хохирол

Дүгнэлт:

2020 оны эхний хагаст Шинэст ХК-ийн үйл ажиллагаанд тодорхой хэлбэрээр ахиц дэвшил гарсан боловч дараах үндсэн зорилгууддаа хүрч ажиллаж чадаагүй.

Үүнд:

- Төлөвлөсөн борлуулалтын орлого биелэгдээгүй
- үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ажилчидын цалин хөлс, тэтгэмжийг нэмэх
- гадна болон үйлдвэрийн доторх сантехникийн шугамын шинэчлэл
-

Шалтгаан нь:

Манай борлуулалт жилээс жилд улам багассаар байна. Иймд бид бүтээгдэхүүнийхээ чанарт илүү анхаарч эхэлсэн. Мөн маркетинг, сурталчилгаа сайн хийж, борлуулалтын сувгаа нэмхээр ажилласаар ирлээ.

Гэвч манай борлуулалтын орлого байгууллагын сарын зардлыг дөнгөж нөхөхүйц, зарим өвлийн саруудад зээл болон бусад эх үүсвэрээр нөхөж байгаа нь үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах дорвитой шийдэлийг эрэлхийлсээр байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Э.Болор /